



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар

А/138

Хархорин сум

Тамхи худалдах үйл ажиллагааг эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 08/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ганган-Орхон багийн Мойлт 6-1 тоот хаягт байрлах “УБЦНЗ” ХХК (3559661)-ийн “Найман зуу-1” 8 нэрийн хүнсний дэлгүүрт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, дэд хурандаа (Д.Отгонбаяр), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Бямбасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100275